



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДАЖ БАЙГАА Ч ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ЗАРИМ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ 118,441.7 САЯ ТӨГРӨГИЙН ТӨСӨВТ ӨРТӨГТЭЙ 26 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСАН, 41,706.5 САЯ ТӨГРӨГИЙН 8 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.**



## АГУУЛГА

<b>Тайлан бэлтгэсэн:</b>	АГУУЛГА	5
<b>Дарга, тэргүүлэх аудитор</b> М.Батсуурь	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	6
<b>Аудитын менежер</b> М.Бат-Амгалан	ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
<b>Ахлах аудитор</b> Т.Намжил	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	9
<b>Аудитор</b> Т.Амармэнд Б.Нямбуу Т.Ариунсайхан	<b>БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа ч хууль, журамд заасан зарим шаардлага хангаагүй 26 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.</b>	9
2025 оны 4 дүгээр сар	<i>1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн байна.</i>	9
	<i>1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлсэн ч эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 3 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.</i>	12
	<i>1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан зураг, төсөвгүй 6, урсгал зардлын тооцоололгүй 2, нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох төсвийн шаардлага хангаагүй 12 төсөл, арга хэмжээ байна.</i>	16
	<i>1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 3 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.</i>	26
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 70453721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	<b>БҮЛЭГ 2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан ч сонгон шалгаруулалттай холбоотой сангийн яаманд 5 гомдол гаргасан, 1 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулаагүй байна.</b>	30
<b>Хаяг:</b> Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	<i>2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.</i>	30
	<i>2.1.1. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд нийцүүлэн боловсруулан батлуулсан байна.</i>	30
	<i>2.1.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.</i>	31
	<i>2.1.3. Тендер шалгаруулалтын аргыг зөв сонгон хэрэглэсэн байна.</i>	34
	<i>2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан ч, зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдаж гараагүй, зарим төсөл, арга хэмжээнд оролцогч ирээгүй зэрэг шалтгаанаар худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна.</i>	36

2.3 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд 5 гомдол гаргасан, 1 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулаагүй байна.	38
<b>БҮЛЭГ 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 32 төсөл төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгэн хүлээн авсан, 9 төсөл, арга хэмжээний 2,460.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 6 төсөл, арга хэмжээг зориулалтаар нь ашиглаж эхлээгүй байна.</b>	43
3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.	43
3.2 Тайлант онд бүрэн хэрэгжих эрх шилжүүлсэн 26 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэсэн байна.	48
3.3 Хөрөнгө оруулалтын 32 төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан байна.	50
3.4 Хэрэгжиж дууссан 9 төсөл, арга хэмжээний 2,460.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 6 төсөл, арга хэмжээг зориулалтаар нь ашиглаж эхлээгүй байна.	54
<b>ДҮГНЭЛТ</b>	58
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ</b>	59
<b>АУДИТЫН ГАЗРААС ӨГӨХ ТАЙЛБАР</b>	64
<b>ЗӨВЛӨМЖ</b>	65

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

УВА	УВС АЙМАГ
ШТА	ШУУД ТАЙЛАГНАХ АУДИТ
ГА	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ТАХ	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ
УТХО	УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
БШУС	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
ХАА	ХӨДӨӨ АЖ АХУЙ
ЗТХС	ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
ХХААХҮС	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
ААН	АЖ АХУЙН НЭГЖ
ХЗДХЯ	ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН ЯАМ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ББЭХС	БАРУУН БҮС ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ
ТӨХК	ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ЗТХЯ	ЗАМ ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН ЯАМ

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилт .....	10
Хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хүргүүлсэн санал.....	13
Хүснэгт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хүргүүлсэн санал.....	13
Хүснэгт 4. Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 3 төсөл, арга хэмжээ .....	15
Хүснэгт 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж .....	17
Хүснэгт 6. Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ.....	19
Хүснэгт 7. Зураг төсөв, магадлалын дүгнэлт шаардлагатай төсөл, арга хэмжээ .....	20
Хүснэгт 8. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар хийгдсэн төсөл, арга хэмжээ ....	21
Хүснэгт 9. Зураг төсөв, магадлалын дүгнэлттэй 6 төсөл, арга хэмжээ .....	22
Хүснэгт 10. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар 5 төсөл, арга хэмжээ .....	22
Хүснэгт 11. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ .....	24
Хүснэгт 12. Урсгал зардлын тооцоо хийгдээгүй төсөл, арга хэмжээ .....	25
Хүснэгт 13. Хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээ .....	27
Хүснэгт 14. Хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж .....	27
Хүснэгт 15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Увс аймагт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ .....	32
Хүснэгт 16. Салбар яамны сайдын багцаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ .....	33
Хүснэгт 17. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээ.....	34
Хүснэгт 18. Тендер шалгаруулалтын хэмнэлт.....	36
Хүснэгт 19. Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 2 төсөл, арга хэмжээ .....	36
Хүснэгт 20. Тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргасан төсөл, арга хэмжээ .....	38
Хүснэгт 21. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ч гэрээ байгуулаагүй 1 төсөл, арга хэмжээ .....	42
Хүснэгт 22. Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн ..	43
Хүснэгт 23. Гүйцэтгэл дутуу, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ .....	45
Хүснэгт 24. Тайлант онд хэрэгжээгүй эрх шилжсэн төсөл, арга хэмжээ .....	46
Хүснэгт 25. Барьцаа хөрөнгийн дансанд 2024 онд санхүүжилтийн үлдэгдлийг байршуулсан төсөл, арга хэмжээ .....	47
Хүснэгт 26. Он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 21 төсөл, арга хэмжээ .....	48
Хүснэгт 27. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт .....	50
Хүснэгт 28. Тайлант онд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ .....	52
Хүснэгт 29. Зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй төсөл, арга хэмжээ .....	56

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ**

## Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

## Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх.
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

## Хамарсан хүрээ

Аудитыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуулиар баталсан 55 төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийлээ.

Аудитад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд санхүүжүүлэхээр баталсан 55 төсөл, арга хэмжээ, Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга болон түүний харьяа байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.

## Арга зүй

АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан,

тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглав.

### **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн**

Аудитыг нэгдсэн удирдамжаар хийх бөгөөд Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Намжил, аудитор Т.Амармэнд, Б.Нямбуу, Т.Ариунсайхан нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөрт тусгагдсан хугацаанд санхүүгийн тайлангийн аудит зэрэг хийгдсэнээс шалтгаалан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг газар дээр нь очиж үзэх боломжгүй байсан болно. Аудитын хүрээнд Улаангом сум болон хөдөөгийн 5 суманд очиж ажилласан бөгөөд бусад сумдад хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг цахимаар зургийг авч баримтжууллаа.

### **Ерөнхий зүйл**

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 27 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 607, тухайн оноос эхлэн хэрэгжих 712, нийт 11,579.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1319 төсөл, арга хэмжээг 3,828.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт санхүүжилтийн 75.7 хувийг 1020 барилга, байгууламжид 13.9 хувийг 235 тоног төхөөрөмж, 8.3 хувийг 16 ТЭЗҮ боловсруулах, 2.1 хувийг 48 их засварын төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар тусгажээ. Мөн нийт 1319 төсөл, арга хэмжээний 56 хувь буюу 740 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөжээ.

Увс аймагт 2024 оны төсвийн тухай хуулиар 212,286.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2024 онд олгох санхүүжилт нь 68,761.3 сая төгрөг байна. Мөн Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 4,505.6 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ байна.

## **БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН**

## ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДАЖ БАЙГАА Ч ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ЗАРИМ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ 26 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

### 1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана”, 27.1.8 дахь заалтад “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бэлтгэнэ”, 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1.2</sup> дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29<sup>1.2.5</sup> дахь заалтад “Тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1-д заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно”, 5.2.12 дахь заалтад “Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим” гэж “дээрээс доош” төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, “доороос дээш” төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг”, 5.2.17 дахь заалтад “Төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим” гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг”, 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна”, 6.10.1 дэх хэсэгт “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх”, 6.10.3 дахь заалтад “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж тус тус заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн байна.

Увс аймагт Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 212,286.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2024 онд олгох санхүүжилт нь 68,761.3 сая төгрөг байна. Мөн Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 4,505.6 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэхээр батлагдсан 55 төсөл, арга хэмжээний хувьд Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны дараах зорилтуудад нийцсэн ажлууд байна. Тухайлбал:

- ❖ Зорилт 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.
- ❖ Зорилт 9.2. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.
- ❖ Зорилт 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.
- ❖ Зорилт 2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.
- ❖ Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Увс аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцэж байна. Тухайлбал:

#### Хүснэгт 1. Бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилт

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичгийн нэр	Зорилго	Зорилт
1	Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор баталсан “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”	<p>Зорилго 2: Хүний хөгжил:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсрол</li> <li>- Эрүүл мэнд</li> </ul> <p>Зорилго 4: Эдийн засаг:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Эдийн засгийн тэргүүлэх чиглэл</li> </ul> <p>Зорилго 6: Ногоон хөгжил:</p> <p>Зорилго 8: Бүс, сум, орон нутгийн хөгжил:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Дэд бүтэц</li> </ul>	<p>Зорилт 2.1: Хүн бүрд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.</p> <p>Зорилт 2.2: Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.</p> <p>Зорилт 4.2: Аймгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэн тогтоож, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.</p> <p>Зорилт 4.5: Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.</p> <p>Зорилт 6.3: Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт 8.1: Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.</p> <p>Зорилт 8.2: Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.</p>
2	Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл	<p>Зорилго 2: Хүний хөгжлийн бодлого:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсрол</li> <li>- Эрүүл мэнд</li> </ul> <p>Зорилго 3: Эдийн засгийн бодлого:</p>	<p>Зорилт 2.1: Хүн бүрд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.</p> <p>Зорилт 2.3: Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, хариуцлагатай, хүртээмжтэй, үйлчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгох.</p>

	ажиллагааны хөтөлбөр”	<p>-Эдийн засгийн тэргүүлэх чиглэл /хөдөө аж ахуйн, аялал жуулчлал/</p> <p>Зорилго 5: Ногоон хөгжлийн бодлого:</p> <p>Зорилго 6: Бүс, сум, орон нутгийн хөгжлийн бодлого: -Дэд бүтэц</p>	<p>Зорилт 3.1: Аймгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэн тогтоож, ХАА-н боловсруулах болон хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.</p> <p>Зорилт 3.2: Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, байгаль, эдийн засгийн хөгжлийг хангана.</p> <p>Зорилт 5.1: Усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох.</p> <p>Зорилт 6.1: Эдийн засгийн бүсчлэлийг хөгжүүлэх, орон нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.</p> <p>Зорилт 6.2: Газрын харилцаа, геодез, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, үр дүнд суурилсан хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>
3	Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/03 дугаар тогтоолоор баталсан “Увс аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”	<p>-Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээг 1.5 хувиар нэмэгдүүлэх</p> <p>-Боловсролын чанарын үзүүлэлтийг 0.5 хувиар нэмэгдүүлэх</p> <p>-Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог 1.5 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>-Өдөрт дасгал хөдөлгөөн хийдэг иргэдийн тоог 5 хувиар нэмэгдүүлэх.</p> <p>-Нийгмийн соён гэгээрлийн түвшинг 1 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>-Эрүүл идэвхтэй ахмад настныг 20 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>-Иргэдийн олон талт хэрэгцээг хангасан орчныг 1 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>-Төрийн үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн дунд үнэлгээг нэмэгдүүлнэ.</p> <p>-Хил зөрчлийн тоог 10 хувиар бууруулна.</p> <p>-Хөдөлгөөнт холбоо 4 G үйлчилгээ авдаг иргэдийн тоог 3 хувиар нэмэгдүүлнэ.</p>	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр дараах төсөл, арга хэмжээнүүдийг нэршил байршлыг тодорхой тусгаж баталсан байна. Үүнд:</p> <p>- Цэцэрлэгийн барилга 2 суманд барих</p> <p>-Ерөнхий боловсролын 6 сургууль барих, дотуур байрны барилга 3 барих, Сургуулийн тоног төхөөрөмж 3 сумдад авах.</p> <p>-Эрүүл мэндийн төвийн авто машин 2 ширхэг, эрүүл мэндийн тоног төхөөрөмж сумдын болон өрхийн ЭМТ-д, Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл 1 суманд.</p> <p>- 5 суманд заалны барилга, аймгийн төвд Усан бассейн, спорт фитнесийн барилга</p> <p>-2 суманд Соёлын төвийн барилга, Музейн тоног төхөөрөмж, 1 сумын соёлын төвийн тоног төхөөрөмж, аймгийн Ойрад театрын барилга, их засварын зураг.</p> <p>-1 суманд ахмадын төвийн тоног төхөөрөмж</p> <p>-Улаангом сумын төвийн тохижилт, сум багийн орчныг тохижуулах “Шинэ гудамж” төсөл.</p> <p>-Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилга, төрийн байгууллагын тоног төхөөрөмж, төрийн үйлчилгээний анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж.</p> <p>-Хилийн цэргийн 0245-р ангийн спорт заалны барилгын их засвар</p> <p>-Үүрэг холбооны дахин дамжуулах сүлжээ станц 6 суманд.</p>

		<p>-Жилийн 4 улиралд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тоог 3 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>-Тарьсан модны ургалтыг 80 хувьд хүргэнэ.</p> <p>-Импортоор авдаг эрчим хүчний хэрэглээг бууруулна.</p> <p>-Ачаа тээврийн урсгалыг 0.1 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>-Стандартын шаардлага хангасан ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүйн нийлүүлэгчдийн тоог 5 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>-Үйлчилгээний экспорт хийдэг ААН, иргэний тоог 3 хувиар нэмэгдүүлнэ.</p>	<p>-Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга, аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отголох цэг 3 суманд Увс, Хяргас нуур дагуу</p> <p>-Чигжийн голын хөв цөөрөм</p> <p>-Улаангом дулааны 2-р станцын зуухны барилгын их засвар</p> <p>-Увс- Ховд аймаг чиглэлийн зам, Улаангом - Тэс чиглэлийн зам, Увс нуур-Улаангом чиглэлийн зам, Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун чиглэлийн замын зураг, аймгийн төвд 2 чиглэлийн зам, Турууны гол болон Хангилцагийн голын гүүр Баруунтуруун суманд үр тарианы агуулах байгуулах, Арсайн газар тариалангийн услалтын систем, Бизнес инкубатор төвийн барилга, Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга, Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл</p>
--	--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эх сурвалж: Увс аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төслийн санал

## 1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлсэн ч эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 3 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.5.5 дахь заалтад “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх”, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана”, 27.1.1 дэх заалтад “Төсвийн зарчмыг мөрдлөг болгох”, 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1</sup>.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна” гэж заажээ.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 2.3.1.1-д “Тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний

саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх”, 2.3.1.2-д “Тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг төсвийн төсөлд тусгуулахаар тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүргүүлэхдээ нийт сумдын болон багийн Иргэдийн нийтийн хурлын саналыг авч аймгийн Засаг даргын тамгын газарт эрэмбэ тогтоож, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан эрэмбэлж төлөвлөсөн байна. Увс аймгийн Засаг дарга 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 1/790 дүгээр бичгээр Увс аймагт Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр 230,285.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 49 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн саналыг жагсаалтаар хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хүргүүлсэн санал

Д/д	Яамны нэр	Төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн саналын тоо	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Шадар сайд	5	14,614.0
2	ХЗДХЯ	2	3,492.02
3	Барилга хот байгуулалтын яам	7	49,752.45
4	Эрчим хүчний яам	1	976.92
5	Зам тээвэр хөгжлийн яам	7	95,451.21
6	Эрүүл мэндийн яам	4	7,786.0
7	БШУЯам	8	37,006.7
8	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	2	2,220.65
9	Байгаль орчин аялал жуулчлалын яам	5	1,394.35
10	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	3	678.84
11	Соёлын сайд	5	16,912.56
	<b>Нийт</b>	<b>49</b>	<b>230,285.7</b>

Эх сурвалж: Увс аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төслийн санал

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 1/1289 дүгээр бичгээр Увс аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төслийн саналыг салбар яамдад хүргүүлжээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр 24,050.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төслийн саналыг жагсаалтаар хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хүргүүлсэн санал

Д/д	Яамны нэр	Төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн саналын тоо	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Шадар сайд	2	190.0
2	ХЗДХЯ	3	664.05
3	Барилга хот байгуулалтын яам	4	7,274.6

4	Эрчим хүчний яам	6	4,070.0
5	Зам тээвэр хөгжлийн яам	4	3,102.0
6	Эрүүл мэндийн яам	4	351.0
7	БШУЯам	3	1,727.97
8	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	4	2,860.0
9	Байгаль орчин аялал жуулчлалын яам	1	600.0
10	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	1	750.0
11	Соёлын сайд	2	1,359.5
12	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1	100.0
13	Үндэсний статистикийн хорооны дарга	1	80.0
14	Монгол улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	1	921.2
<b>Нийт</b>		<b>37</b>	<b>24,050.3</b>

Эх сурвалж: Увс аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төслийн санал

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.1-д "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын удирдлагыг хариуцан ажиллах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 2.1.1-д "Төсөл, арга хэмжээний саналыг энэ журамд зааснаар хүлээн авах, боловсруулах, нэгтгэх, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналт, тайлагналтын удирдлагыг хэрэгжүүлэх", 2.1.2-д "Төсөл, арга хэмжээний төсвийн эрсдэлийн үнэлгээг хийх, тухайн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргах", 2.1.3-д "Төсөл, арга хэмжээг холбогдох журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах санал боловсруулах" гэж заасан байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар баталсан 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад Увс аймгийн Засаг даргын хүргүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн 49 саналаас 12 саналыг дэмжиж, 92,488.8 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийг баталсан байна. Үүнд:

- Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/-4,670.5 сая
- Турууны голын төмөр бетон гүүр, 109.15 у/м, Бухын голын 9.6 у/м гүүр, 1.1 км авто зам /Увс, Баруунтуруун сум/-6,431.5 сая
- Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Бөхмөрөн сум/-9,507.7 сая
- Ерөнхий боловсролын сургуулийн олон улсын стандарт хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байр, иж бүрэн хөл бөмбөгийн талбай /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/-10,000.0 сая
- Дотуур байрны барилга, 160 суудал /Увс, Өмнөговь сум, 5 дугаар баг/-5,480.25 сая
- Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун сум/-900.0 сая
- Соёлын төвийн барилга /Увс, Малчин сум/-3,750.0 сая
- Спорт заалны барилга /Увс, Цагаанхайрхан сум/-2,554.8 сая
- Спорт заалны барилга /Увс, Өмнөговь сум/-2,535.0 сая
- Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/-46,659.1 сая

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар баталсан 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад Увс аймгийн Засаг даргын хүргүүлсэн их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төслийн 37 саналаас 1,900.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнд:

- Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/-1,100.0 сая төгрөг
- Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/-800.0 сая төгрөг

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2-д "Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага", 3.2.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна", 3.2.2-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй", 3.2.2.3-д "Шаардлагатай тохиолдолд төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл (цаашид "ТЭЗҮ" гэх), техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа (цаашид "ТЭЗУС" гэх) хийлгэсэн байх" гэж заасан байхад Сангийн яамнаас эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 3 төсөл, арга хэмжээг төлөвлөн тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 4. Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 3 төсөл, арга хэмжээ

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XVI.1.14	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/	2022	2024	2,978.40	948.80
2	XVI.3.15	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	450.00	450.00
3	XVI.3.1	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материал	2024	2024	100.00	100.00
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 2 Зөөлөн оёдлын тоног төхөөрөмж иж бүрдэл	2024	2024	350.00	350.00
		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц4 Чацарганы хөргүүртэй зоорины тоног төхөөрөмж, тусгаарлагч материал, сэлбэг хэрэгсэл	2024	2024	100.00	100.00

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Дээрх хөрөнгүүдийн ашиглалтын талаар тодруулахад аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 61 дүгээр албан бичгээр дараах тайлбарыг ирүүлсэн.

- ❖ Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/ төсөл, арга хэмжээний хувьд түрээсийн нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж тоног төхөөрөмжтэй өрөөнүүдийг 4 жилийн хугацаатайгаар, зарим сул өрөөнүүдийг 1 жилийн хугацаатайгаар түрээслүүлэн, үлдсэн өрөөнд сонгон шалгаруулалт зарлахаар бэлтгэж байна. Хатуу оёдлын 6 өрөө бүхий 278 м.кв талбайг 4 жилийн хугацаатайгаар нийт 73.4 сая төгрөгөөр, зөөлөн оёдлын 2 өрөө бүхий 112 м.кв талбайг 4 жилийн хугацаатайгаар нийт 24.2 сая төгрөгөөр түрээслүүлсэн.
- ❖ Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/ төсөл, арга хэмжээний хүрээнд 102.0 сая төгрөгөөр худалдан авсан тоног төхөөрөмжийг 4 жилийн хугацаатайгаар түрээслүүлэхээр гэрээ байгуулсан ч цахилгаан холболт хийгдээгүйгээс ашиглаж эхлээгүй байна.
- ❖ Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/, Багц 2 зөөлөн оёдлын тоног төхөөрөмжийн иж бүрдэлийг 85.2 сая төгрөгөөр худалдан авч 4 жилийн хугацаатайгаар түрээслүүлэхээр гэрээ байгуулсан ч цахилгаан холболт хийгдээгүйгээс ашиглаж эхлээгүй байна.
- ❖ Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/, Багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материалыг ашиглаж эхлээгүй.
- ❖ Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/, Багц 4 Чацарганы хөргүүртэй зоорины тоног төхөөрөмж, тусгаарлагч материал, сэлбэг хэрэгсэлийн хүрээнд ирсэн тоног төхөөрөмжийг хүлээн авсан ч, аймгийн ЗДТГ-ын аж ахуйн хашаанд байна. Барилга угсралтын ажил зарлагдан, ажлыг хүлээн авснаар ашиглаж эхлэхээр байна.

### 1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан зураг, төсөвгүй 6, урсгал зардлын тооцоололгүй 2, нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох төсвийн шаардлага хангаагүй 12 төсөл, арга хэмжээ байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана” гэж заажээ. Үүнд:

- 29.3.1. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;
- 29.3.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;
- 29.3.3. нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;
- 29.3.4. санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;
- 29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;
- 29.3.6. тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна”, 6.10.2 дахь заалтад “Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” гэж заажээ.

Хүснэгт 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	V.3.7	Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	600.0	600.0
2	V.3.13	Төрийн үйлчилгээний анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	600.0	600.0
3	IX.1.1.1	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилга /Увс, Улаангом сум/	2022	2024	2,653.6	785.2
4	X.3.2.5	Хилийн цэргийн 0245 дугаар ангийн спорт заалны барилгын их засвар /Увс, Улаангом сум/	2024	2024	350.0	350.0
5	XII.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	2024	2026	250.0	50.0
6	XIII.1.1.35	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	2019	2024	5,117.2	527.6
7	XIII.1.1.148	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Увс, Ховд сум/	2021	2024	1,007.7	347.7
8	XIII.1.1.164	Дотуур байрны барилга, 100 ор /Увс, Наранбулаг сум/	2022	2024	4,617.8	2,045.1
9	XIII.1.1.184	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Завхан сум/	2022	2024	7,324.7	5,644.4
10	XIII.1.1.185	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Хяргас сум/	2022	2024	7,342.9	4,011.5
11	XIII.1.1.194	Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2022	2025	15,469.4	7,300.0
12	XIII.1.1.268	Дотуур байрны барилга, 160 суудал /Увс, Өмнөговь сум, 5 дугаар баг/	2024	2026	5,480.3	1,644.1
13	XIII.1.1.271	Ерөнхий боловсролын сургуулийн олон улсын стандарт хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байр, иж бүрэн хөл бөмбөгийн талбай /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2024	2026	10,000.0	2,235.5
14	XIII.1.1.294	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Бөхмөрөн сум/	2024	2026	9,507.7	2,852.3
15	XIII.1.1.295	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Давст сум/	2024	2026	9,507.7	2,852.3
16	XIII.1.1.366	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	2026	3,473.8	1,042.1
17	XIII.1.3.35	Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/	2024	2024	535.0	535.0
18	XIV.5.3.1	Ахмадын төвийн тоног төхөөрөмж /Увс, Сагил сум/	2024	2024	50.0	50.0
19	XV.1.1.3	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	2019	2024	1,939.8	158.1
20	XV.1.1.43	Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	2024	2026	3,602.0	1,080.6
21	XV.1.1.79	Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/	2024	2026	46,659.1	6,840.3
22	XV.1.1.82	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	2024	2026	4,670.5	1,600.0
23	XV.1.4.4	Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/	2024	2024	1,100.0	1,100.0
24	XV.2.1.2	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	2022	2024	576.5	60.0

25	XV.2.1.5	Турууны голын төмөр бетон гүүр, 109.15 у/м, Бухын голын 9.6 у/м гүүр, 1.1 км авто зам /Увс, Баруунтуруун сум/	2024	2026	6,431.5	1,929.5
26	XVI.1.1.6	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	2024	2026	1,500.0	500.0
27	XVI.1.1.7	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/	2024	2025	1,874.1	874.1
28	XVI.1.1.9	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	2024	2025	1,200.0	600.0
29	XVI.2.1.5	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	2019	2024	15,373.6	4,559.9
30	XVI.2.1.47	Соёлын төвийн барилга /Увс, Малчин сум/	2024	2026	3,750.0	755.0
31	XVI.2.1.62	Соёлын төвийн өргөтгөл, шинэчлэл /Увс, Зүүнхангай сум/	2024	2024	952.3	952.3
32	XVI.2.3.4	Музейн тоног төхөөрөмж /Увс, Улаангом сум/	2024	2024	100.0	100.0
33	XVI.2.3.18	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Увс, Тэс сум/	2024	2024	60.0	60.0
34	XVI.3.1.12	Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/	2019	2024	4,100.0	1,192.0
35	XVI.3.1.16	Спорт заалны барилга /Увс, Малчин сум/	2021	2024	1,394.7	362.4
36	XVI.3.1.17	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	2021	2024	2,535.8	28.6
37	XVI.3.1.33	Спорт заалны барилга /Увс, Ховд сум/	2024	2025	2,554.8	1,277.4
38	XVI.3.1.34	Спорт заалны барилга /Увс, Цагаанхайрхан сум/	2024	2025	2,554.8	1,277.4
39	XVI.3.1.35	Спорт заалны барилга /Увс, Өмнөговь сум/	2024	2026	2,535.0	1,000.0
40	XVII.1.21	Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/	2021	2024	967.4	104.8
41	XVII.1.23	Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/	2021	2024	440.4	37.0
42	XVII.1.50	Сум, багийн орчныг тохижуулах "Шинэ гудамж" төсөл /Увс, Улаангом сум/	2022	2024	953.6	100.0
43	XVIII.1.12	Арсайн газар тариалангийн услалтын систем /Увс, Улаангом сум/	2022	2024	3,635.0	1,061.0
44	XVIII.1.13	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2022	2024	2,300.1	1,850.1
45	XVIII.1.14	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/	2022	2024	2,978.4	948.8
46	XVIII.1.23	Үр тариа хадгалах агуулах /Увс, Дорнод/	2022	2025	2,481.1	1,250.0
47	XVIII.3.1	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/	2021	2024	4,500.0	1,008.5
48	XVIII.3.14	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	450.0	450.0
49	XIX.1.4	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун сум/	2024	2024	900.0	900.0
50	XIX.1.5	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	2024	2026	900.0	270.0
51	XX.2.1	Зуухны барилгын их засвар /Увс, Улаангом сум/	2024	2024	240.7	240.7
52	XXI.1.35	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Увс, Давст сум/	2022	2025	1,527.3	100.0
53	XXI.3.25	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	400.0	400.0
54	XXI.3.34	Эрүүл мэндийн төвийн автомашин /Увс, Улаангом сум, 2, 8 дугаар баг/	2024	2024	160.0	160.0
55	XXI.3.36	Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Увс, Ховд сум/	2024	2024	100.0	100.0
		<b>НИЙТ</b>			<b>212,286.3</b>	<b>68,761.3</b>

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг өмнөх оны хөрөнгө оруулалттай харьцуулахад 7 төсөл, арга хэмжээгээр буюу санхүүжилтийн хувьд 145,932.9 сая

төгрөгөөр өссөн байна. Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 6. Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/	800.0
2	Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тариалан сум, Хархираа баг/	239.0
3	Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Улаангом сум	760.0
4	Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум/	120.0
5	Тэс сумын халаалтын зуухны засвар, шинэчлэл /Увс, Тэс сум/	240.7
6	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 10 дугаар баг/	263.5
7	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Өлгий сум/	150.0
8	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 12 дугаар баг/	250.0
9	Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах-Автовышка /Увс, Улаангом сум/	1,200.0
10	Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/	196.0
11	Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг	286.4
	<b>Нийт</b>	<b>4,505.6</b>

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1.1</sup> дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, 29<sup>1.2</sup> дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх” гэж заажээ. Үүнд:

- ❖ 29<sup>1.2.1</sup> дэх заалтад “тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”
- ❖ 29<sup>1.2.2</sup> дахь заалтад “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”
- ❖ 29<sup>1.2.3</sup> дахь заалтад “техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх”
- ❖ 29<sup>1.2.4</sup> дэх заалтад “урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх”
- ❖ 29<sup>1.2.5</sup> дахь заалтад “тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх”
- ❖ 29<sup>1.2.6</sup> дахь заалтад “олон нийтээр хэлэлцүүлсэн байх”

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3 дахь заалтад “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй 22 төсөл, арга хэмжээнээс 2019-2022 онд хэрэгжиж эхэлсэн 7, тайлант онд шинээр хэрэгжиж эхэлсэн болон он дамжин хэрэгжиж байгаа 15 төсөл, арга хэмжээ байна. Тайлант онд шинээр хэрэгжүүлж эхлэх 15 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, магадлалын дүгнэлт шаардлагатай, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдох 9 төсөл, арга хэмжээ, ажлын даалгавар техникийн тодорхойлолттой 6 төсөл, арга хэмжээ байна.

#### Хүснэгт 7. Зураг төсөв, магадлалын дүгнэлт шаардлагатай төсөл, арга хэмжээ

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая.төгрөг)	Магадлалын дүгнэлт (огноо, дугаар)
1	VI.1.11	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	1,200.00	Багц 1-2024.10.10 1841/2024, Багц 2-2024.10.10 1840/2024
2	VI.1.18	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	250.00	Зураг төсвийн ажил дуусаагүй, санхүүжилт бүрэн олгогдоогүй
3	VI.1.8	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	1,500.00	Зураг төсөв магадлалаар баталгаажаагүй
4	VI.1.9	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/	1,874.10	Зураг төсөв магадлалаар баталгаажаагүй
5	XIII.1.1.366	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	3,473.80	2024.07.26 1273/2024
6	XV.1.1.82	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	4,670.50	2024.06.07 218/2024
7	XV.1.4.4	Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/	1,100.00	Зураг төсвийн ажил дуусаагүй, санхүүжилт бүрэн олгогдоогүй
8	XXV.1.5	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	900.00	Нэг маягийн зураг
9	XVII.2.1	Зуухны барилгын их засвар /Увс, Улаангом сум/	240.70	2024.06.20 919/2024

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Судалгаанаас харахад Төсийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Засгийн газар барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 32.1.11 дэх заалтад “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх” гэж заасан байхад Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар хуульд заасан шаардлага хангаагүй буюу зураг төсөвгүй 6 төсөл, арга хэмжээг баталж зураг төсвийг хийлгэсэн байна.

Энэ нь тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөвт өртөг нэмэгдэх, зориулалт өөрчлөгдөх зэрэг сөрөг үр дагаврууд гарах эрсдэл үүсгэж байна.

Иймд дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд зөвлөмжөөр тусгуулах санал хүргүүлж байна.

Хүснэгт 8. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар хийгдсэн төсөл, арга хэмжээ

№	Хуулийн код	Хуулийн төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая.төгрөг)	Техникийн тодорхойлолт (Ажлын даалгаврын огноо)
1	XVIII.3.1	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материал	100.00	2024.05.06
			Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 2 Зөөлөн оёдлын тоног төхөөрөмж иж бүрдэл	350.00	2024.03.25
			Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 3 Сумын багийн эмч нарт автомашин, тоног төхөөрөмж	408.50	2024.09.10
			Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 4 Чацарганы хөргүүртэй зоорины тоног төхөөрөмж, тусгаарлагч материал, сэлбэг хэрэгсэл	100.00	2024.05.13
			Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 5 Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/	50.00	2024.05.13
2	V.3.12	Төрийн үйлчилгээг анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж /Увс/	600.00	2024.01.02	
3	XI.5.3.1	Ахмадын төвийн тоног төхөөрөмж /Увс, Сагил сум/	50.00	2024.03.21	
4	XIII.1.3.35	Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/ багц 1	435.0	2024.03.20	

		Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/ багц 2	100.0	2024.03.20
5	XIV.3.18	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Увс, Тэс сум/	60.00	2024.04.04
6	XVI.3.15	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/	450.00	2024.03.04

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээнээс 6 төсөл арга хэмжээ зураг төсөв, магадлалын дүгнэлттэй, 5 төсөл, арга хэмжээ техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар хийгдсэн байна. Үүнд:

Хүснэгт 9. Зураг төсөв, магадлалын дүгнэлттэй 6 төсөл, арга хэмжээ

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая.төгрөг)	Магадлалын дүгнэлт (огноо, дугаар)
1	XX.1.39-6.1.1	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Улаангом сум багц 1	760.00	2024.05.27 279/2024
2	XX.1.39-6.1.2	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц2	286.40	2024.10.31 947/2024
3	XX.1.39-6.2.1	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тариалан сум, Хархираа баг/ багц1	239.00	2024.05.27 278/2024
4	XX.1.39-6.2.2	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/ багц2	196.00	2024.07.26 522/2024
5	XX.1.39-6.3.1	Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум/	120.00	2024.06.07 324/2024
6	XX.1.39-6.3.2	Тэс сумын халаалтын зуухны засвар, шинэчлэл /Увс,Тэс сум/	240.70	2024.08.21 611/2024

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Хүснэгт 10. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар 5 төсөл, арга хэмжээ

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая.төгрөг)	Техникийн тодорхойлолт (Ажлын даалгаврын огноо)
1	XX.3.2-2.1	Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл	1,200.00	2024.05.19

		худалдан авах-Автовышка /Увс, Улаангом сум/		
2	ХХ.3.2-2.2	Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/	800.00	2024.04.29
3	ХХ.3.2-2.3-1	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 10 дугаар баг/ багц1	263.50	2024.05.06
4	ХХ.3.2-2.3-2	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 12 дугаар баг/ багц2	250.00	2024.04.22
5	ХХ.3.2-2.3-3	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Өлгий сум/ багц3	150.00	2024.05.06

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэгт “Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж тухайн ашиглагч байгууллагын саналыг авч барилга байгууламжийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас төсөл, арга хэмжээ бүрд зураг төсөл зохиох ажлын даалгаврыг боловсруулж, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцөлүүдийг гаргуулах талаар барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаварт тусгажээ.

Түүнчлэн газар олгох захирамжийг гаргахдаа өмнөх онд гаргаж батлуулсан төлөвлөгөөнд үндэслэдэг байна.

Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт “Барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах үе шатыг зураг төслийн байгууллагатай байгуулсан гэрээ болон зургийн даалгаварт тусгана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллажээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар баталсан Увс аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтад “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.3.4.2-т “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төслийн нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэсэн шаардлагыг

хангаагүй 12 төсөл, арга хэмжээг Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгасан байна.

Хүснэгт 11. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг (сая.төг)	2024 онд санхүүжих дүн (сая.төг)	Хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилагдбал зохих хамгийн бага дүн (сая.төг)	Зөрүү (сая.төг)
1	XIII.1.1.271	Ерөнхий боловсролын сургуулийн олон улсын стандарт хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байр, иж бүрэн хөл бөмбөгийн талбай /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2024	2026	10,000.0	2,235.5	3,333.3	(1,097.8)
2	XIII.1.1.294	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Бөхмөрөн сум/	2024	2026	9,507.7	2,852.3	3,169.2	(316.9)
3	XIII.1.1.295	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Давст сум/	2024	2026	9,507.7	2,852.3	3,169.2	(316.9)
4	XIII.1.1.366	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	2026	3,473.8	1,042.1	1,157.9	(115.8)
5	XV.1.1.43	Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	2024	2026	3,602.0	1,080.6	1,200.7	(120.1)
6	XV.1.1.79	Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/	2024	2026	46,659.1	6,840.3	15,553.0	(8,712.7)
7	XV.2.1.5	Турууны голын төмөр бетон гүүр, 109.15 у/м, Бухын голын 9.6 у/м гүүр, 1.1 км авто зам /Увс, Баруунтуруун сум/	2024	2026	6,431.5	1,929.5	2,143.8	(214.3)
8	XVI.1.1.7	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс,	2024	2025	1,874.1	874.1	937.0	(629.5)

		Тариалан сум, Увс нуур/						
9	XVI.2.1.47	Соёлын төвийн барилга /Увс, Малчин сум/	2024	2026	3,750.0	755.0	1,250.0	(495.0)
10	XIX.1.5	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	2024	2026	900.0	270.0	300.0	(30.0)
11	XXI.1.35	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Увс, Давст сум/	2022	2025	1,527.3	100.0	381.8	(281.8)
12	VI.1.18	Чигжийн голын хөв цөөрөм /Увс, Өндөрхангай сум/	2024	2026	250.00	50.00	83.3	(33.3)

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх 12 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс 30.0 – 8,712.7 сая төгрөгийг дутуу хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.3.1-28.3.8, 28.3.12-т заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийнэ” гэж заасны дагуу Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/-46,649.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2024 онд 6,840.3 сая төгрөгийн санхүүжилт баталсан төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1.2</sup> дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29<sup>1.2.4</sup> дэх заалтад “урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх” гэж заасан байхад урсгал зардлын тооцоо хийгдээгүй бүрэн хэрэгжиж дууссан 2 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

Хүснэгт 12. Урсгал зардлын тооцоо хийгдээгүй төсөл, арга хэмжээ

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XVI.1.13	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2022	2024	2,300.05	1,850.06
2	XVI.1.14	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/	2022	2024	2,978.40	948.80

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Аймгийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 20/06 дугаар тогтоолоор дээрх 2 барилгуудын үйл ажиллагааг нэгтгэн удирдан зохион байгуулах

чиг үүрэг бүхий нэгжийг аймгийн ЗДТГ-ын дэргэд “Бизнесийн хөгжлийг дэмжих төв” нэртэйгээр байгуулсан байна.

Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/ ашиглалтад орсонтой холбоотойгоор аймгийн ЗДТГ-ын төсвөөс 2024 оны 10 дугаар сараас 2025 оны 03 дугаар сарын хооронд нийт 128.1 сая төгрөгийн зардал гарсан байна. Үүнд:

- Түлш халаалт 54.9 сая,
- Цахилгаан 3.4 сая,
- Цэвэр бохир усны төлбөр 0.4 сая,
- Цалингийн зардал 69.4 сая төгрөг /Менежер-1, инженер-1, харуул-4, үйлчлэгч-1, нийт 7 хүн ажиллаж байна. /Бүтэц, орон тоо баталсан шийдвэр байхгүй/

Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/ ашиглалтад орсонтой холбоотойгоор аймгийн ЗДТГ-ын төсвөөс 2025 оны 01 дүгээр сараас 3-р сарын хооронд нийт 24.1 сая төгрөгийн зардал гарсан байна. Тухайн барилгыг ашиглаж эхлээгүй байна.

- Түлш халаалт 23.8 сая,
- Цахилгаан 0.3 сая,

#### **1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 3 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.**

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтад "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ" гэж заажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.2 дахь заалтад “Хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”, 13.4 дэх хэсэгт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.4.1 дэх заалтад “Орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт”, 13.4.5 дахь заалтад “Айл, өрхийн ариун цэврийн байгууламж, гудамжны тохижилт” гэж заасан байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар баталсан Увс аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй, хувийн өмчид шилжих 2, Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Хүснэгт 13. Хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээ

/сая төгрөг/

Д/Д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах			
1	XII.1.21	Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/	2021	2024	7,800.0	967.42	104.76
2	XII.1.50	Сум, багийн орчныг тохижуулах "Шинэ гудамж" төсөл /Увс, Улаангом сум/	2022	2024	1000.0	953.56	100.00

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/ төсөл, арга хэмжээний хүрээнд Улаангом сумын гэр хорооллын зам дагуу байршилтай айл өрхүүдийн хашаа, хаалгыг шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн.

Сум, багийн орчныг тохижуулах "Шинэ гудамж" төсөл /Увс, Улаангом сум/ төсөл, арга хэмжээний хүрээнд Улаангом сумын гэр хорооллын зарим багийн айл өрхүүдийн хашаанд хогийн сав, гэр хорооллын хаягжуулалт хийсэн байна.



Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/49 дүгээр тушаалаар сайдын багцаас эрх шилжиж хэрэгжүүлсэн Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/-800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээ байна.

Уг ажлыг "Мэйжүрмэнт" ХХК тендерт шалгарч 787.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр ЭХЯ/20240102061 дугаар гэрээг байгуулан гүйцэтгэж, 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн "Тоног төхөөрөмж хүлээн авах" А/483 дугаар актаар хүлээн авсан байна. Үүнд дараах тоног төхөөрөмж хүлээн авсан байна. Үүнд:

Хүснэгт 14. Хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж

Нэр төрөл, марк	Үйлдвэрлэсэн улс, байгууллага огноо	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
DDZY-88 Загварын 1 фазын ухаалаг цахилгааны тоолуур	БНХАУ, Beijing banner electric co.2024 он	3100	209,000	647,900,000
DTZY88 Загварын 3 фазын ухаалаг цахилгааны тоолуур	БНХАУ, Beijing banner electric co.2024 он	36	770,000	27,720,000
DJGZ23-BN01 загварын концентратор /DCU/	БНХАУ, Beijing banner electric co.2024 он	36	1,650,000	59,400,000
R740 сервер Silver	БНХАУ, DELL co.2024 он	1	17,600,000	17,600,000

UPS3000VA/1800W тог баригч	БНХАУ, Beijing banner electric co.2024 он	1	1,210,000	1,210,000
TP900 загварын гар удирдлага	БНХАУ, Beijing banner electric co.2024 он	2	1,540,000	3,080,000
Кабель (зэс хатуу ) ПВ-1*10	Монгол улс Эрдмин ХХК 2024 он	3100	9,900	30,690,000
<b>Нийт</b>				<b>787,600,000</b>

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх тоног төхөөрөмжийг “Увс Цахилгаан түгээх сүлжээ” ХХК хүлээн авч Улаангом сумын Улиасны хэв гаргалгааны станцуудын хэрэглэгчдэд 1284 ширхэг, Нэгдэл дундын үйлчилгээний гаргалгааны хэрэглэгчдэд 859 ширхэг, Баруун тойрог гаргалгааны хэрэглэгчдэд 383 ширхэг, Тариалан гаргалгааны хэрэглэгчдэд 512 ширхэг, Тэс сумын Таван улиас, Хар үзүүр, Шар үзүүрийн хэрэглэгчдэд 62 ширхэг, нийт 3100 тоолуурыг үнэ төлбөргүйгээр суурилуулсан байна.



Дээрх ухаалаг тоолуурыг суурилуулснаар хэрэглэгчдийг тэжээж буй дэд станцуудын алдагдал, цахилгаан эрчим хүчний авлага, тоолуур болон борлуулалтын ажилтантай холбоотой санал гомдол буурч, цахилгаан эрчим хүчний үнийг бодитой тооцох, гэр хорооллын айл өрхүүд шөнийн хөнгөлөлтөд хамрагдах боломж бүрдсэн байна.

Хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээг хуульд тусган батлуулахгүй байх асуудлыг Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална”, 13.1.4 дэх заалтад “Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” гэж заасан байна.

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/48 дугаар тушаалаар сайдын багцаас эрх шилжиж хэрэгжүүлсэн орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц 2 - 284.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зураг төсөв нь 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр магадлалаар орж баталгаажсан байх бөгөөд

тендер шалгаруулалтыг зохион байгуулж "Оточ-Эрчим" ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулсан байна. Тухайн төсөл, арга хэмжээ нь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан тухайн онд хэрэгжээгүй байна.

Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөмж болгов.

## БҮЛЭГ 2. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН 4 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ САНГИЙН ЯАМАНД 5 ГОМДОЛ ГАРГАСАН, 1 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ГЭРЭЭ БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.


2.1.1. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд нийцүүлэн боловсруулан батлуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй 22 төсөл, арга хэмжээнээс 2019-2022 онд хэрэгжиж эхэлсэн 7, тайлант онд шинээр хэрэгжиж эхэлсэн болон он дамжин хэрэгжиж байгаа 15 төсөл, арга хэмжээ, мөн Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд хэрэгжих эрх шилжиж ирсэн шинээр хэрэгжиж эхлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 32 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Нийт төлөвлөсөн худалдан авах ажиллагааны 55.4 хувийн санхүүжилтийг 2024 онд олгохоор төлөвлөсөн бөгөөд 7 төсөл, арга хэмжээ нь 2025-2026 он дамжин санхүүжихээр байна. Үүнд:

- Багц 1: Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс, Наранбулаг сум/
- Багц 2 : Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс, Цагаанхайрхан сум/
- Чигжийн голын хөв цөөрөм /Увс, Өндөрхангай сум/
- Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/
- Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/
- Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/


Төлөвлөсөн худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээг зориулалтаар нь авч үзвэл дараах байдалтай байна.



2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 50.0 хувь нь тоног төхөөрөмж, 28.1 хувь нь барилга байгууламж, 15.6 хувь нь их засвар, 6.3 хувь нь ТЭЗҮ байна.

Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.1-д “Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна”, 2.2-д “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” гэж заасан байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжиж ирсэн 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2024 оны 05 дугаар сард багтаан зарлахаар төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа дараах байдалтай байна. Үүнд:



Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжиж ирсэн 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

### 2.1.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ”, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Захиалагчийг төлөөлөх этгээд энэ хуулиар олгогдсон эрх, үүргийг тухайн байгууллагын холбогдох бусад этгээдэд шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна” гэж заажээ. Үүнд:

4.1.1.1.Төсвийн тухай хуулийн 14.4-т заасныг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг хэсэгчилж, эсхүл бүхэлд нь шилжүүлэх

4.1.1.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх;

4.1.1.3.төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Төсвийн тухай хуулийн 14, 61 дүгээр зүйлийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлэх.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжиж ирсэн 26 төсөл, арга хэмжээ байна.

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 409 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг баталсан байна. Уг тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Увс аймагт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс 13 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна. Төсвийн эрх захирагчаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Увс аймагт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ

Д/д	Төсвийн захирагч	Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ
1	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	Төрийн үйлчилгээг анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж /Увс/-600.0 сая төгрөг
2	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	<ul style="list-style-type: none"> <li>Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/-1,500.0 сая төгрөг</li> <li>Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/-1,874.1 сая төгрөг</li> <li>Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/-1,200.0 сая төгрөг</li> <li>Чигжийн голын хөв цөөрөм /Увс, Өндөрхангай сум/-250.0 сая төгрөг</li> </ul>
3	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Ахмадын төвийн тоног төхөөрөмж /Увс, Сагил сум/-50.0 сая төгрөг
4	Боловсрол, Шинжлэх Ухааны сайд	<ul style="list-style-type: none"> <li>Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/-3,473.8 сая төгрөг</li> <li>Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/-535.0 сая төгрөг</li> </ul>
5	Соёлын сайд	Соёлын төвийн тоног төхөөрөмж/Увс, Тэс сум/-60.0 сая төгрөг

		<ul style="list-style-type: none"> <li>Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/-1,100.0</li> </ul>
6	Зам, тээврийн хөгжлийн сайд	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/-4,670.5 сая төгрөг
7	Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/-450.0 сая төгрөг
8	Эрчим хүчний сайд	Зуухны барилгын их засвар /Увс, Улаангом/-240.7 сая төгрөг

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Аймгийн Засаг даргад 13 төсөл, арга хэмжээг салбар яамны сайдын багцаас тушаалаар ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрхийг шилжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 16. Салбар яамны сайдын багцаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ

Д/д	Төсвийн захирагч	Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ
1	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/133 дугаар тушаал	<ul style="list-style-type: none"> <li>“Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц/Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/”-270.0 сая төгрөг</li> </ul>
2	Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/84 дүгээр тушаал	“Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/”-535.0 сая төгрөг
3	Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/48, А/49 дүгээр тушаал	<ul style="list-style-type: none"> <li>“Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Ховд сум 1,2 баг /”-286.4 сая төгрөг;</li> <li>“Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Увс, Улаангом сум/”-760.0 сая төгрөг;</li> <li>Сумдын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тариалан сум, Хархираа баг/-239.0 сая төгрөг</li> <li>Сумдын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/-196.0 сая төгрөг</li> <li>Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум/-120.0 сая төгрөг</li> <li>Тэс сумын халаалтын зуухны засвар шинэчлэл /Увс, Тэс сум/-240.7 сая төгрөг</li> <li>Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах /Увс, Улаангом сум/-1,200.0 сая төгрөг</li> <li>Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/-800.0 сая төгрөг</li> <li>Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Улаангом сум 10-р баг/-263.5 сая төгрөг</li> <li>Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Улаангом сум 12-р баг/-250.0 сая төгрөг</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Өлгий сум/-150.0 сая төгрөг</li> </ul>
--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

### 2.1.3. Тендер шалгаруулалтын аргыг зөв сонгон хэрэглэсэн байна.

Худалдан авах ажиллагааны газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд хэрэгжих шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжиж ирсэн 26 төсөл, арга хэмжээний хүрээнд 32 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 30 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан бөгөөд 28 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалт, 2 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын арга ашигласан байна.

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-т заасан төсөвт өртөгт нийцүүлэн тендер шалгаруулалтын аргыг зөв сонгон хэрэглэсэн байна.

Хүснэгт 17. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Худалдан авалтын арга	Төсөвт өртөг	Гэрээ байгуулсан дүн
1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	Нээлттэй	3,473.8	3,473.6
2	Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/	Нээлттэй	1,100.0	1,068.5
3	Багц 1 Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс, Наранбулаг сум/	Нээлттэй	800.0	796.5
4	Багц 2 Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс, Цагаанхайрхан сум/	Нээлттэй	400.0	399.8
5	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	Нээлттэй	900.0	900.0
6	багц 1 Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Увс, Улаангом сум/	Нээлттэй	760.0	750.0
7	багц 2 Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Увс, Ховд сум 1,2 баг /	Нээлттэй	286.4	284.0
8	XVII.1.39.6.3 Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл, Тэс сумын халаалтын зуухны засвар, шинэчлэл /Увс, Улаангом, Тэс сум/ багц 1 8 дугаар цэцэрлэг	Нээлттэй	120.0	118.6
9	XVII.1.39.6.3 Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл, Тэс сумын халаалтын зуухны засвар, шинэчлэл /Увс, Улаангом, Тэс сум/ багц 2 Тэс сум	Нээлттэй	240.7	239.8

10	Багц 1 Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тариалан сум, Хархираа баг/	Нээлттэй	239.0	236.0
11	Багц 2 Сумдын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/	Нээлттэй	196.0	180.0
12	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	Нээлттэй	4,670.5	4,668.7
13	Чигжийн голын хөв цөөрөм /Увс, Өндөрхангай сум/	Нээлттэй	250.0	245.0
14	Зуухны барилгын их засвар /Увс, Улаангом сум/	Нээлттэй	240.7	238.0
15	Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/	Нээлттэй	800.0	787.6
16	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/	Нээлттэй	450.0	450.0
17	Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/ багц 1	Нээлттэй	435.0	412.8
18	Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/ багц 2 /дотоодод үйлдвэрлэсэн бараа/	Нээлттэй	100.0	97.9
19	Ахмадын төвийн тоног төхөөрөмж /Увс, Сагил сум/	Харьцуулалт	50.0	47.3
20	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Улаангом, Өлгий сум/ багц 1 буюу 10 дугаар багийн гэрэлтүүлэг	Нээлттэй	263.5	258.9
21	багц 2 буюу Улаангом сумын 12 дугаар багийн гэрэлтүүлэг	Нээлттэй	250.0	246.4
22	багц 3 буюу Өлгий сумын гэрэлтүүлэг	Нээлттэй	150.0	146.9
23	Төрийн үйлчилгээг анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж /Увс/	Нээлттэй	600.0	597.9
24	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Увс, Тэс сум/	Харьцуулалт	60.0	54.2
25	Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах /Увс, Улаангом сум/	Нээлттэй	1,200.0	1,100.0
26	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материал	Нээлттэй	100.0	99.9
27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 2 Зөөлөн оёдлын тоног төхөөрөмж иж бүрдэл худалдан авах	Нээлттэй	350.0	347.0
28	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 3 Сумын багийн эмч нарт автомашин, тоног төхөөрөмж	Нээлттэй	408.5	408.5
29	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 Чацарганы хөргүүртэй зоорины тоног төхөөрөмж, тусгаарлагч материал, сэлбэг хэрэгсэл	Нээлттэй	100.0	98.9
30	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 5 Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/	Нээлттэй	50.0	-

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Худалдан авах ажиллагааны газраас 18,934.1 сая төгрөгийн 28 худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын, 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар тус тус зохион байгуулсан байна. Тендер шалгаруулалттай холбоотойгоор 241.4 сая төгрөгийн санхүүжилтийн хэмнэлт гарсан байна.

## Хүснэгт 18. Тендер шалгаруулалтын хэмнэлт

сая төгрөгөөр

№	Тендер шалгаруулалтын арга	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэмнэлт
1	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	18,884.1	18,651.2	232.9
2	Харьцуулалтын тендер шалгаруулалтын арга	110.0	101.5	8.5
	Нийт	18,994.1	18,752.7	241.4

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

## Хүснэгт 19. Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 2 төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Шалтгаан
1	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	Тус төсөл арга хэмжээ хэрэгжих газрыг Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хандан 1 га газрыг эзэмших эрхийн гэрчилгээг аймгийн ЗДТГ-т гаргуулж авсан. Мөн холбогдох техникийн тодорхойлолтуудыг холбогдох байгууллагуудаас гаргуулсан. Инженер геологийн судалгааны ажлыг “Хангай инж гео” ХХК, зураг төслийг “Пауэрхаус девелопмент групп” ХХК боловсруулсан ч барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлт гараагүйгээс шалтгаалан тендер шалгаруулалт зарлаагүй байна.
2	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/	

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

## 2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан ч, зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдаж гараагүй, зарим төсөл, арга хэмжээнд оролцогч ирээгүй зэрэг шалтгаанаар худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулсан 30 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд 18 үнэлгээний хороог ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн 50.1.1 дэх заалт, 50.1.2 дахь заалтын дагуу 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг баталсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.4, 50.5, 50.6 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл, Засаг даргын Тамгын газрын ажилтан, тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт “Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна”, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 2.11 дэх заалтад “Захиалагч үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилох мэргэшсэн ажилтныг мэргэшсэн ажилтны бүртгэлд бүртгэлтэй эсэх, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах хууль, журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгана” гэж заажээ. Үнэлгээний хорооны гишүүнээр


ажилласан гишүүдийн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээг <https://new.tender.gov.mn/mn/exam/certificate> цахим системээс шалгахад 2 тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажилласан 2 гишүүний худалдан авах ажиллагааны гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан байхад үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулсан байна.

Цаашид үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны мэргэшсэн эрхийн гэрчилгээ нь хүчинтэй байгаа иргэнийг ажиллуулахыг зөвлөлөө.

Төсөл сонгон шалгаруулах бүх үнэлгээний хорооны гишүүд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцох бүртээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална”, 11.2 дахь хэсэгт “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана” гэж заасны дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулжээ.

Худалдан авах ажиллагааны газраас 2024 онд зарласан 30 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтаас 1 тендерийг төлөвлөсөн хугацаандаа, 29 тендерийг төлөвлөгөөт хугацаанаас 3-259 хоногоор хэтрүүлэн зарласан байна. Энэ нь тухайн бараа, ажил, үйлчилгээний зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдаж ирэхгүй хугацаа алдсанаас шалтгаалжээ.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “51.2.Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ” гэж заасны дагуу 16 худалдан авах ажиллагааны материалыг тендер нээсэн өдрөө хянан үзэж, үнэлэх ажиллагааг хийсэн бол 13 худалдан авах ажиллагааны үнэлгээг ажлын 1-4 хоногийн дараа хийсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ” заасны дагуу 9 худалдан авах ажиллагааны гэрээг захиалагчаас гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6-аас доошгүй буюу тогтоосон хугацаанд багтаан тендерт шалгарсан оролцогчид байгуулсан байна. Харин 8 худалдан авах ажиллагааны гэрээг тендерт шалгарсан оролцогч захиалагчаас тогтоосон хугацаанаас ажлын 2-21 хоног хэтрүүлэн гэрээг баталгаажуулсан байна. Цаашид хуульд заасан хугацааг мөрдөж ажиллахыг зөвлөлөө.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Захиалагч доор дурдсан тохиолдолд энэ хуулийн 30.1-д заасан хугацааны дараа гэрээ байгуулах хугацааг баримтлахгүй байж болно”, 30.2.1 дэх заалтад “тендер шалгаруулалтад нэг оролцогч тендер ирүүлж шалгарсан” гэж заасны дагуу 12 худалдан авах ажиллагааны гэрээг байгуулжээ.

### **2.3 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд 5 гомдол гаргасан, 1 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулаагүй байна.**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана” гэж заасны дагуу 30 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын зарлалыг <https://user.tender.gov.mn/mn/invitation> цахим системд бүрэн нийтэлсэн нь тендер оролцогчдыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг хангасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Тендер оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана” гэж заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлагдсан 6 тендер оролцогч Сангийн яаманд гомдол гаргасан бөгөөд 1 оролцогч гомдлоо буцаасан байна. Бусад 5 гомдлыг Сангийн яам хянан үзэж гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгож, тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх мэдэгдэл хүргүүлжээ. Үүнд: Хүснэгт 20. Тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргасан төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гомдол гаргасан оролцогчийн нэр	Сангийн яамны шийдвэрлэлт	Эцсийн шийдвэрлэлт
1	Багц 1: Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс, Наранбулаг сум/	“Увс өгөөмөр өгөөж” ХХК	Дахин үнэлгээ хийх	Сангийн яаманд ирсэн гомдлын дагуу үнэлгээний хороо хуралдан дахин үнэлгээ хийж тендерийн хорооны гишүүд саналаа хэвээр үлдээсэн. шүүхэд хандаж гомдол гаргаж захиалагч талд шийдвэр гарсан.
2	Багц 1: Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/	“Майтеч” ХХК	Дахин үнэлгээ хийх	Сангийн яаманд ирсэн гомдлын дагуу үнэлгээний хороо хуралдан дахин үнэлгээ хийж гишүүд саналаа хэвээр үлдээсэн.
3	Багц 2: Сумдын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/	“Бүрэн холбоо констракшн” ХХК	Дахин үнэлгээ хийх	Сангийн яаманд ирсэн гомдлын дагуу үнэлгээний хороо хуралдан дахин үнэлгээ хийж гишүүд саналаа хэвээр үлдээсэн.
4	Багц 1: Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Увс, Улаангом сум/	“Пи эс Пи” ХХК “Оточ Эрчим” ХХК	Дахин үнэлгээ хийх	Сангийн яаманд ирсэн гомдлын дагуу үнэлгээний хороо хуралдан дахин үнэлгээ хийж гишүүд саналаа хэвээр үлдээсэн. /Сангийн яамны 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Тендер түдгэлзүүлэх тухай” албан бичгийг гэрээ байгуулагдсаны дараа буюу 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Худалдан авах ажиллагааны газарт ирүүлсэн/
5	Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах-Автовышка /Увс, Улаангом сум/	“Хантуул Трейд” ХХК	Дахин үнэлгээ хийх	Тайлбар*
6	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	“ЗГБ Холдинг” ХХК	Гомдол гаргасан “ЗГБ Холдинг” ХХК гомдлоо буцаасан	

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Сангийн яаманд ирсэн гомдлын дагуу хянагдаж гомдлыг үндэслэлтэй гэж үзэн дахин үнэлгээ хийх тухай зөвлөмж ирүүлсний дагуу 4 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтад үнэлгээний хороо хуралдан дахин үнэлгээ хийсэн ч тендерийн хорооны гишүүд саналаа хэвээр үлдээсэн байна. Сангийн яам гомдлыг

үндэслэлтэй гэж үзэн дахин үнэлгээ хийх тухай зөвлөмж ирүүлсэн ч сонгон шалгаруулалтыг хуучин хэвээр үлдээсэн асуудалд хэрхэн хяналт хийх талаар хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс сонгон шалгаруулалтын маргаан гарч шүүхийн байгууллагад шилжин шалгагдах, төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэж байна.

Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах-Автовышка /Увс, Улаангом сум/ төсөл, арга хэмжээний хувьд 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр тендер нээж, үнэлгээний хороо тендерийг үнэлэн хурлаас гарсан зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн байна. Захиалагч 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/1156 дугаар албан бичгээр “Меса Инженеринг” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэн бөгөөд гэрээг захиалагчийн тогтоосон хугацаанд буюу 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 80 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ” гэж заасан байна.

Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах /Увс, Улаангом сум/ 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд “Хан туул трейд” ХХК 968.0 сая төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн, тендерийн материал нь шаардлага хангасан байсан ч тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны гишүүдийн олонх нь “төсөвт өртгийн 80 хувьтай ойр үнийн саналтай чанар муу техник нийлүүлэх магадлалтай” гэж санал өгснөөр бага үнийн санал ирүүлсэн тухайн компанийг сонгоогүй байна.

Дээрх тендерийн хорооны шийдвэртэй холбоотойгоор “Хан туул трейд” ХХК-ний зүгээс “... үнийн санал нь чанаргүй бараа нийлүүлэх эрсдэлтэй гэж санал болгосон Бүгд найрамдах Солонгос улсад үйлдвэрлэсэн Daewoo маркийн автомашин болон NOVAS брэндийн сагстай өргөгчийн техникийн үзүүлэлтийг харгалзахгүйгээр тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй ...” талаар тусгаж Сангийн яаманд гомдол гаргасан байна.


Уг гомдлын дагуу Сангийн яамны 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 03/5763 дугаар “Гомдол хянасан тухай” албан бичгээр “... тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцэх эсэхэд үнэлгээ хийгээгүй байх тул хянан үзэх шаардлагатай байна” гэж тусган захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдсэн байна.

Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-т “Сангийн яам хуулийн 59.6-д заасан захиалагчийг үйлдэл хийхгүй байхыг даалгах, захиалагчийн шийдвэрийг түдгэлзүүлэх шийдвэрийг захиалагч, түүний үнэлгээний хорооны гишүүнд утсаар, эсхүл цахим системээр мэдэгдэнэ” гэж заасан байхад Сангийн яамны 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Тендер түдгэлзүүлэх тухай” албан бичгийг гэрээ байгуулагдсаны дараа буюу 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр аймгийн Худалдан авах ажиллагааны газарт ирүүлсэн байна.

Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 3.9-д “Хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага, эсхүл шүүхээс тендер

шалгаруулалтын баримт бичиг өөрчлөлт оруулах, эсхүл тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг дахин хийх, эсхүл захиалагчийг тендерийн үнэлгээний хорооны зөвлөмжид хяналт тавихыг даалгасан тохиолдолд захиалагч үнэлгээний хороог хуралдуулж шийдвэр гаргана” гэж заасныг дагуу худалдан авах ажиллагааны газраас тухайн ажилд үнэлгээ дахин хийх хуралдаан товлох тухай 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 47 дугаар албан бичгийг аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст мэдэгдсэн боловч захиалагчийн зүгээс үнэлгээний хороог хуралдуулаагүй, дахин үнэлгээ хийгээгүй байна.

Тухайн хөрөнгийг гэрээний дагуу 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн УТ2403000737002 дугаар комиссын актаар “ББЭХС” ТӨХК-д хүлээлгэн өгсөн байна.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 59.2-т зааснаар урьдчилан шийдвэрлүүлэх журмаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд худалдан авах гэрээ байгуулснаас хойш гаргасан гомдлыг шүүхэд гаргана” гэж заасны дагуу оролцогч шүүхэд гомдол гаргасан бөгөөд Сум дундын анхан шатны шүүхийн шийдвэрээр захиалагчийн талд шийдвэр гарсан байна. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр Сум дундын анхан шатны шүүхийн шийдвэрийг буцаасан байна.

Уг тендерт оролцсон 5 компани ирүүлсэн үнийн санал нь хаана үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж гэдгээс шалтгаалан харилцан адилгүй буюу хамгийн бага үнийн санал нь 848.5 сая төгрөг, хамгийн өндөр үнийн санал нь 1,100.0 сая төгрөг буюу 251.5 сая төгрөгийн зөрүүтэй, захиалагчийн зүгээс техникийн нөхцөл боловсруулахдаа холбогдох үнийн судалгаа хийгээгүй зэргээс үзэхэд тухайн тоног төхөөрөмжийг бэлтгэн нийлүүлсэн үнэлгээ нь зах зээлийн бодит үнэлгээнд нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Иймд дээрх Сангийн яаманд гомдол гаргасан 5 худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөмж чиглэл өгч ажиллах талаар УАГ-ын нэгтгэл тайланд тусгаж холбогдох яам, агентлагт уламжлуулах саналыг хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь заалтад “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу цаглаварт хугацаанд Худалдан авах ажиллагааны газар тайлагнасан байна.

Мөн Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.4-д “Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны тайланг цахим системд байршуулсан байна.

Хүснэгт 21. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ч гэрээ байгуулаагүй 1 төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Шалтгаан
1	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 5 Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/	Худалдан авах ажиллагааг 11 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй байна.

*Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт*

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/-ийн арга хэмжээний хүрээнд 5 багц арга хэмжээнд тендер зарласнаас “Багц 5: Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/”-ийн худалдан авах ажиллагааг 6 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй байна.

**БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 32 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭН ХҮЛЭЭН АВСАН, 9 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2,460.3 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙГ ДАНС БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ, 6 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗОРИУЛАЛТААР НЬ АШИГЛАЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙНА.**

**3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн 22 төсөл, арга хэмжээ, Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээ нийт 33 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 22. Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжих дүн /сая.төг/
			Эхлэх	Дуусах		
1	V.3.7	Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	600.0	600.0
2	XII.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	2024	2026	250.0	50.0
3	XIII.1.1.35	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	2019	2024	5,117.2	527.6
4	XIII.1.1.366	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	2026	3,473.8	1,042.1
5	XIII.1.3.35	Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/	2024	2024	535.0	535.0
6	XIV.5.3.1	Ахмадын төвийн тоног төхөөрөмж /Увс, Сагил сум/	2024	2024	50.0	50.0
7	XV.1.1.3	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	2019	2024	1,939.8	158.1
8	XV.1.1.82	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	2024	2026	4,670.5	1,600.0
9	XV.1.4.4	Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/	2024	2024	1,100.0	1,100.0
10	XV.2.1.2	Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/	2022	2024	576.5	60.0
11	XVI.1.1.6	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	2024	2026	1,500.0	500.0
12	XVI.1.1.7	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/	2024	2025	1,874.1	874.1
13	XVI.1.1.9	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	2024	2025	1,200.0	600.0
14	XVI.2.1.5	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	2019	2024	15,373.6	4,559.9
15	XVI.2.3.18	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Увс, Тэс сум/	2024	2024	60.0	60.0
16	XVI.3.1.12	Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/	2019	2024	4,100.0	1,192.0
17	XVIII.1.13	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2022	2024	2,300.1	1,850.1
18	XVIII.1.14	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/	2022	2024	2,978.4	948.8
19	XVIII.3.1	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/	2021	2024	4,500.0	1,008.5
20	XVIII.3.14	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	450.0	450.0

21	XIX.1.5	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	2024	2026	900.0	270.0
22	XX.2.1	Зуухны барилгын их засвар /Увс, Улаангом сум/	2024	2024	240.7	240.7
23	XX.1.39-6.1.1	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Улаангом сум багц 1	2024	2024	760.0	760.0
24	XX.1.39-6.1.2	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц2	2024	2024	286.4	286.4
25	XX.1.39-6.2.1	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тариалан сум, Хархираа баг/ багц1	2024	2024	239.0	239.0
26	XX.1.39-6.2.2	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/ багц2	2024	2024	196.0	196.0
27	XX.1.39-6.3.1	Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум/	2024	2024	120.0	120.0
28	XX.1.39-6.3.2	Тэс сумын халаалтын зуухны засвар, шинэчлэл /Увс, Тэс сум/	2024	2024	240.7	240.7
29	XX.3.2-2.1	Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах-Автовышка /Увс, Улаангом сум/	2024	2024	1,200.0	1,200.0
30	XX.3.2-2.2	Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/	2024	2024	800.0	800.0
31	XX.3.2-2.3-1	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 10 дугаар баг/ багц1	2024	2024	263.5	263.5
32	XX.3.2-2.3-2	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 12 дугаар баг/ багц2	2024	2024	250.0	250.0
33	XX.3.2-2.3-3	Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Өлгий сум/ багц3	2024	2024	150.0	150.0

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заажээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн эрх шилжиж ирсэн 33 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд бүрэн олгосон байна. Үүнд:

- Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Увс/
- Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/
- Ахмадын төвийн тоног төхөөрөмж /Увс, Сагил сум/
- Хангилцагийн голын модон гүүр, 38.5 у/м /Увс, Цагаанхайрхан сум/

- Соёлын төвийн тоног төхөөрөмж /Увс, Тэс сум/
- Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/
- Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/
- Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/
- Зуухны барилгын их засвар /Увс, Улаангом сум/
- Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Улаангом сум багц 1
- Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тариалан сум, Хархираа баг/ багц1
- Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/ багц2
- Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум/
- Тэс сумын халаалтын зуухны засвар, шинэчлэл /Увс, Тэс сум/
- Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах-Автовышка /Увс, Улаангом сум/
- Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/
- Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 10 дугаар баг/ багц1
- Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал /Увс, Улаангом сум 12 дугаар баг/ багц2
- Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Өлгий сум/ багц3
- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн эрх шилжиж ирсэн 33 төсөл, арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна. Үүнд: Он дамжин хэрэгжүүлэх 3, тайлант онд бүрэн хэрэгжих 2 төсөл, арга хэмжээ байна.

#### Хүснэгт 23. Гүйцэтгэл дутуу, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний эхлэх, дуусах огноо	Ажил эхэлснээс хойш олгосон санхүүжилт	2024 онд олгосон санхүүжилт /сая.төг/	Хэрэгжиж дуусаагүй ТАХ-ны шалтгаан, нөхцөл
1	Чигжийн голын хөв цөөрөм /Увс, Өндөрхангай сум/	250.0	2024.05.24-2025.08.30	50.0	50.0	Гэрээний хугацаа болоогүй гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн.
2	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	4,670.5	2024.06.27-2025.11.30	1,600.0	1,600.0	Гэрээний хугацаа болоогүй гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн.
3	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	900.0	2024.05.10-2025.03.30	270.0	270.0	Гэрээний хугацаа болоогүй гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн.
4	Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун	1,100.0	2024.05.24-2024.09.01	854.8	854.8	Уг төсөл арга хэмжээ 2024-2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан байсан бөгөөд тодотголоор 2024 онд дуусахаар өөрчлөн баталсан

	сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/					байна. Тухайн зураг төсвийн ажил хийгдэж дуусаагүй.
5	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	15,373.6	2019.09.27-2024.12.31	13,693.4	3,420.5	Гэрээний хугацаанд барилгын ажлаа бүрэн гүйцэтгэж дуусгаагүй 2025 оны 01 сарын 16-ны өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авснаар үлдэгдэл санхүүжилтийг олгосон.
	<b>Нийт дүн</b>	<b>22,294.1</b>		<b>16,468.2</b>	<b>6,195.3</b>	

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн эрх шилжиж ирсэн 33 төсөл, арга хэмжээнээс 8 төсөл, арга хэмжээ огт хэрэгжүүлээгүй, санхүүжилт олгоогүй байна. Үүнд:

Хүснэгт 24. Тайлант онд хэрэгжээгүй эрх шилжсэн төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Эрх шилжсэн эсэх
		Эхлэх	Дуусах			
1	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	2019	2024	1,939.8	158.1	Тийм
2	Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/	2019	2024	4,100.0	1,192.0	Тийм
3	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц2	2024	2024	286.4	286.4	Тийм
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 5 Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/-	2024	2024	50.0	50.0	Тийм
5	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	2024	2026	1,500.0	500.0	Тийм
6	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/	2024	2025	1,874.1	874.1	Тийм
7	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	2024	2025	1,200.0	600.0	Тийм
8	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	2026	3,473.8	1,042.1	Тийм
	<b>НИЙТ</b>			<b>14,424.1</b>	<b>4,702.7</b>	

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний үлдэгдэл 2,177.8 сая төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тогтоолыг үндэслэн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Хүснэгт 25. Барьцаа хөрөнгийн дансанд 2024 онд санхүүжилтийн үлдэгдлийг байршуулсан төсөл, арга хэмжээ

Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Барьцаа хөрөнгийн данс	Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа дүн /сая.төг/
XIV.1.5	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	Ув.Сангийн сайдын ЭШХО Төрийн сан	1,680.1
XX.1.39-6.1.2	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц2	Ув.ЭХСайд-ын ЭШХО Төрийн сан	284.0
XV.1.4.4	Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/	Ув.ЗТХСайд ЭШХО Төрийн сан	213.7
<b>Нийт дүн</b>			<b>2,177.8</b>

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц2 ажлын зураг төсөв нь 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр магадлалаар орж баталгаажсан бөгөөд тендер шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгч "Оточ-Эрчим" ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулсан байна. Уг ажил нь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан тайлант онд хэрэгжих боломжгүй болсон тул санхүүжилт 284.0 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Мөн Засгийн газрын 2023 оны 466 дугаар тогтоолыг үндэслэн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байсан өмнөх онд хэрэгжиж дуусаагүй 4 төсөл, арга хэмжээний нийт 2,232.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтээс 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үндэслэн 1,318.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/ төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 675.2 сая
- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 4 буюу "Тэс суманд шаардлагатай тоног төхөөрөмж" төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 102.4 сая
- Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/ төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 504.7 сая

Харин Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар- "ТНХ" ХХК-ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл /Увс, Улаангом сум/ төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг өмнөх онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсныг гүйцэтгэгч компани ажлаа гүйцэтгээгүй тул Сангийн яамны 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02/1136 дугаар албан бичгийг үндэслэн Төрийн сан дахь улсын төсвийн орлогын 10090008005 тоот дансанд 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр төвлөрүүлсэн байна.

### 3.2 Тайлант онд бүрэн хэрэгжих эрх шилжүүлсэн 26 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны Төсвийн тухай хуулиар Увс аймагт хэрэгжүүлэхээр баталсан 55 төсөл, арга хэмжээ, Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээ, нийт 66 арга хэмжээнээс 45 төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихээр, 21 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Хүснэгт 26. Он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 21 төсөл, арга хэмжээ

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XII.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	2024	2026	250.0	50.0
2	XIII.1.1.194	Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2022	2025	15,469.4	7,300.0
3	XIII.1.1.268	Дотуур байрны барилга, 160 суудал /Увс, Өмнөговь сум, 5 дугаар баг/	2024	2026	5,480.3	1,644.1
4	XIII.1.1.271	Ерөнхий боловсролын сургуулийн олон улсын стандарт хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байр, иж бүрэн хөл бөмбөгийн талбай /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2024	2026	10,000.0	2,235.5
5	XIII.1.1.294	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Бөхмөрөн сум/	2024	2026	9,507.7	2,852.3
6	XIII.1.1.295	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Давст сум/	2024	2026	9,507.7	2,852.3
7	XIII.1.1.366	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	2026	3,473.8	1,042.1
8	XV.1.1.43	Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/	2024	2026	3,602.0	1,080.6
9	XV.1.1.79	Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/	2024	2026	46,659.1	6,840.3
10	XV.1.1.82	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	2024	2026	4,670.5	1,600.0
11	XV.2.1.5	Турууны голын төмөр бетон гүүр, 109.15 у/м, Бухын голын 9.6 у/м гүүр, 1.1 км авто зам /Увс, Баруунтуруун сум/	2024	2026	6,431.5	1,929.5
12	XVI.1.1.6	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	2024	2026	1,500.0	500.0
13	XVI.1.1.7	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/	2024	2025	1,874.1	874.1
14	XVI.1.1.9	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	2024	2025	1,200.0	600.0
15	XVI.2.1.47	Соёлын төвийн барилга /Увс, Малчин сум/	2024	2026	3,750.0	755.0
16	XVI.3.1.33	Спорт заалны барилга /Увс, Ховд сум/	2024	2025	2,554.8	1,277.4

17	XVI.3.1.34	Спорт заалны барилга /Увс, Цагаанхайрхан сум/	2024	2025	2,554.8	1,277.4
18	XVI.3.1.35	Спорт заалны барилга /Увс, Өмнөговь сум/	2024	2026	2,535.0	1,000.0
19	XVIII.1.23	Үр тариа хадгалах агуулах /Увс, Дорнод/	2022	2025	2,481.1	1,250.0
20	XIX.1.5	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	2024	2026	900.0	270.0
21	XXI.1.35	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Увс, Давст сум/	2022	2025	1,527.3	100.0
		<b>НИЙТ</b>			<b>135,929.1</b>	<b>37,330.6</b>

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно” гэж заасны дагуу эрх шилжсэн 2 төсөл, арга хэмжээг багцад хуваан хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/31 дүгээр захирамжаар “Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/” төсөл арга хэмжээг 5 багцад задлан баталсан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/ багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материал-100.0 сая төгрөг,
- Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/ Багц 2 Зөөлөн оёдлын тоног төхөөрөмж иж бүрдэл-350.0 сая төгрөг,
- Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/ Багц 3 Сумын багийн эмч нарт автомашин, тоног төхөөрөмж-408.5 сая төгрөг,
- Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/ Багц 4 Чацарганы хөргүүртэй зоорины тоног төхөөрөмж, тусгаарлагч материал, сэлбэг хэрэгсэл-100.0 сая төгрөг,
- Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Увс/ Багц 5 Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/-50.0 сая төгрөг бүхий 5 багцад хуваасан.

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/137 дугаар захирамжаар эрх шилжсэн “Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/” төсөл арга хэмжээг

- Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/ багц 1- 435.0 сая төгрөг,
- Сургуулийн тоног төхөөрөмж /Увс, Сагил, Наранбулаг, Өлгий сум/ багц 2 -100.0 сая төгрөг бүхий 2 багцад хуваасан байна.

Төсвийн тухай хуулиар 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан 45 төсөл, арга хэмжээнээс Увс аймагт эрх шилжин хэрэгжсэн 26 төсөл, арга хэмжээ байгаагаас 20 төсөл, арга хэмжээ, багцад задарсан 4 төсөл, арга хэмжээ, нийт 24 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолт, ажлын даалгавар болон батлагдсан зураг төсөл, захиалагчтай байгуулсан гэрээний дагуу үе шатны ажил болгон дээр хяналт хийж ил далд ажлын актаар баталгаажуулан Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 16 дугаар хавсралтаар баталсан “Гэрээ дүгнэх маягт”-ын дагуу гэрээг дүгнэн хүлээн авсан байна.

Төсвийн тухай хуулиар 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан Увс аймагт эрх шилжин хэрэгжсэн 26 төсөл, арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаагүйгээс гэрээг дүгнээгүй байна. Үүнд:

- Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/- “Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/” ажлыг 1,917,299,352 төгрөгөөр хийж гүйцэтгэн 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын комисст хүлээлгэн өгөхөөр ЗТХЯ/201901023 дугаартай гэрээ байгуулсан. Өнөөдрийн байдлаар ажлыг хэрэгжилт хангалтгүй, ажил зогссон байдалтай байна.
- Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/- Тухайн ажил нь 2022 оноос хойш царцсан байдалтай байгаа бөгөөд 2024 онд ямар нэг ажил хийгдээгүй.
- Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц2- Ажлын зураг төсөв нь 2024 оны 10 сарын 28-ны өдөр магадлалаар орж баталгаажсан бөгөөд тендер шалгаруулалтыг зохион байгуулан "Оточ-Эрчим" ХХК-тай 2024 оны 11сарын 11-ны өдөр гэрээ байгуулсан. Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан төсөл, арга хэмжээ тухайн онд хэрэгжээгүй.
- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 5 Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/- Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч оролцоогүй учраас хэрэгжээгүй байна.
- Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/- Уг төсөл арга хэмжээ 2024-2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан байсан бөгөөд тодотголоор 2024 онд дуусахаар өөрчлөн баталсан байна. Тухайн зураг төсвийн ажил хийгдэж дуусаагүй.
- Аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/- Гэрээний хугацаанд барилгын ажлаа бүрэн гүйцэтгэж дуусаагүй 2025 оны 01 сарын 16-ны өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авснаар үлдэгдэл санхүүжилтийг олгосон.

### 3.3 Хөрөнгө оруулалтын 32 төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан байна.

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд Увс аймагт хэрэгжихээр батлагдсан 55 төсөл, арга хэмжээнээс эрх шилжээгүй 33, эрх шилжиж ирсэн 22 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 34 төсөл арга хэмжээ, он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 21 төсөл, арга хэмжээ, байна. Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 2024 онд хэрэгжиж дуусах 11 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 27. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Д/д	Эрх шилжүүлсэн эсэх	Бүрэн хэрэгжсэн	Дутуу хэрэгжсэн	Огт хэрэгжээгүй	Нийт
1	Эрх шилжүүлсэн	20	5	8	33
2	Эрх шилжүүлээгүй	12	14	7	33
	<b>Нийт</b>	<b>32</b>	<b>19</b>	<b>15</b>	<b>66</b>

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх заалтад “Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт

тавих”, 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.1-д “Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үе шат бүр дээр хэрэгжүүлэн ажилласан байна. Ингэхдээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажлын актаар баталгаажуулж, гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх талаар зөвлөмж чиглэл өгсөн байна. Мөн гүйцэтгэл нь дууссан төсөл, арга хэмжээ бүрд улсын комисс ажиллуулах Засаг даргын захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд “Барилга байгууламж ашиглалтад оруулах”, 48.1 дэх хэсэгт “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 8.2-т “Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 8.2.1-д “Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргана” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж дүгнэлт гарган барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 66 төсөл, арга хэмжээнээс эрх шилжээгүй 12, эрх шилжиж ирсэн 20 төсөл, арга хэмжээ, нийт 32 төсөл, арга хэмжээг захиалагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, төсвөөр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу үе шатны ажил болгон дээр хяналт хийж ажлын актаар баталгаажуулж хүлээн авсан байна.

Төрийн үйлчилгээний анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж /Увс/ гэсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 597.9 сая төгрөгийн 22 автомашиныг, Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл Багц 3, Сумын багийн эмч нарт автомашин, тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 279.7 сая төгрөгийн 14 автомашиныг тус тус бэлтгэн нийлүүлсэн байна. Уг автомашинууд дээр шинэ хөдөө “UBC” гэсэн бичигтэй ирсний “UBC” гэсэн нь U.vs >Увс аймаг, B.usiness > Бизнес, C.luster > Кластер гэсэн утгатай хувийн аж ахуйн нэгжийн гаргасан брэндийн нэрийн товчлол байна. Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн тоног төхөөрөмж дээр сурталчилгааны чанартай нэршил байршуулахгүй байх зөвлөмжийг УАГ-ын нэгтгэл тайланд тусгуулах санал хүргүүлж байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 66 төсөл, арга хэмжээнээс эрх шилжээгүй 14, эрх шилжиж ирсэн 5 төсөл, арга хэмжээ, нийт 19 төсөл, арга хэмжээг дутуу хэрэгжүүлснээс 8 төсөл, арга хэмжээ нь 2024 онд бүрэн хэрэгжүүлж дуусахаар байжээ. Үүнд:

- Аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/- Гэрээний хугацаанд барилгын ажлаа бүрэн гүйцэтгэж дуусгаагүй 2025 оны 01 сарын 16-ны өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан байна.
- Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/- Уг төсөл арга хэмжээ 2024-2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан байсан бөгөөд тодотголоор 2024 онд дуусахаар өөрчлөн баталсан байна. Тухайн зураг төсвийн ажил хийгдэж дуусаагүй.
- Дотуур байрны барилга, 100 ор /Увс, Наранбулаг сум/-2024
- Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Завхан сум/-2024
- Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Хяргас сум/-2024
- Арсайн газар тариалангийн услалтын систем /Увс, Улаангом сум/-2024
- Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун сум/-2024
- Спорт заалны барилга /Увс, Малчин сум/-2024

Дээрх 8 төсөл, арга хэмжээнээс “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/ гэсэн ажлыг 2025 оны 1 дүгээр сард бүрэн дуусгаж хүлээн авсан байна.

Гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлж хүлээн авахыг зөвлөмж болгов.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 66 төсөл, арга хэмжээнээс 15 төсөл, арга хэмжээний хүрээнд 2024 онд ямар нэг ажил хийгдээгүй байна. Үүнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2024 онд шинээр баталсан он дамжин хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээ, 2024 онд хэрэгжиж дуусах 3 төсөл, арга хэмжээ, урд оноос шилжин 2024 онд хэрэгжиж дуусах 3 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 28. Тайлант онд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Эрх шилжсэн эсэх
		Эхлэх	Дуусах			
1	Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/	2019	2024	1,939.8	158.1	Тийм
2	Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/	2019	2024	4,100.0	1,192.0	Тийм
3	Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/	2021	2024	440.4	37.0	Үгүй
4	Төрийн үйлчилгээг анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж /Увс/	2024	2024	600.0	600.0	Үгүй
5	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Ховд сум, 1, 2 баг-багц2	2024	2024	286.4	286.4	Тийм
6	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 5 Хөргүүрийн агуулахын угсралт, тоног төхөөрөмж /Тэс сум/-	2024	2024	50.0	50.0	Тийм
7	Ерөнхий боловсролын сургуулийн олон улсын стандарт хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байр, иж бүрэн хөл бөмбөгийн талбай /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2024	2026	10,000.0	2,235.5	Үгүй
8	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Бөхмөрөн сум/	2024	2026	9,507.7	2,852.3	Үгүй
9	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	2026	3,473.8	1,042.1	Тийм
10	Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/	2024	2026	46,659.1	6,840.3	Үгүй
11	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	2024	2026	1,500.0	500.0	Тийм
12	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/	2024	2025	1,874.1	874.1	Тийм
13	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	2024	2025	1,200.0	600.0	Тийм
14	Спорт заалны барилга /Увс, Ховд сум/	2024	2025	2,554.8	1,277.4	Үгүй
15	Спорт заалны барилга /Увс, Цагаанхайрхан сум/	2024	2025	2,554.8	1,277.4	Үгүй
	<b>НИЙТ</b>			<b>86,740.9</b>	<b>19,822.6</b>	

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх төсөл, арга хэмжээний хувьд анх батлахдаа зураг төсөв, магадлалын дүгнэлт гараагүй, худалдан авах ажиллагааг оройтож зарласан, оролцогч орж ирээгүй зэргээс шалтгаалан хугацаа алдсан болон гүйцэтгэгч компани ажлыг гүйцэтгээгүй царцаасантай холбоотойгоор 2024 онд хэрэгжээгүй ажлууд байна. Тухайлбал:

- “Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс” ажлын зураг төслийг Чулуутын багш ХХК боловсруулан, тендерийн сонгон шалгаруулалтыг 2 багцад хуваан Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан ч барилгын ажил эхлээгүй,
- “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/”, “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/” арга хэмжээний хувьд хэрэгжих газрыг Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хандан 1 га газрыг эзэмших эрхийн гэрчилгээг АЗДТГ дээр гаргуулан, инженер геологийн судалгааны ажлыг Хангай инж гео ХХК, Зураг төслийг “Пауэрхаус девелопмент групп” ХХК боловсруулж барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтээр баталгаажуулж хэрэгжээгүй,
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/ төсөл арга хэмжээний зураг төслийг Болор төсөл ХХК ЗТ-28/2023 дугаартай гэрээний дагуу боловсруулж захиалагчид хүлээлгэн өгч, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр Зоос импекс ХХК шалгарч гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч 10 сард шалгарсан учир цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан барилга угсралтын ажил эхлээгүй,
- “Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл /Увс, Улаангом сум, 1 дүгээр баг/” ажлыг 1,917,299,352 төгрөгөөр хийж гүйцэтгэн 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын комисст хүлээлгэн өгөхөөр ЗТХЯ/201901023 дугаартай гэрээ байгуулсан боловч өнөөдрийн байдлаар ажлыг хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэгч компанийн буруугаас шалтгаалан ажил зогссон байдалтай байна.

Улаангом дулааны 2-р станцын зуухны барилгын их засвар ажлыг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10/2024 дүгнэлтийн хавсралт хурлын тэмдэглэлээр 15 үүрэг даалгавар өгч хүлээж авсан байна. Уг комиссын өгсөн үүрэг даалгавраас 4 үүрэг даалгавар биелээгүй байна. Комиссын өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ажиллах зөвлөмж өгөв.

### **3.4 Хэрэгжиж дууссан 9 төсөл, арга хэмжээний 2,460.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 6 төсөл, арга хэмжээг зориулалтаар нь ашиглаж эхлээгүй байна.**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан дараах төсөл, арга хэмжээнүүд Төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй, харьяа яамнаас хөрөнгийн үнийн жагсаалт ирээгүй, ашиглагч байгууллагад тухайн хөрөнгийг хүлээн авсан комиссын актыг хүргүүлээгүй зэрэг шалтгаанаар данс бүртгэлд тусгаагүй 2,460.3 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материал-99.9 сая төгрөг,
- ✓ Зуухны барилгын их засвар /Увс, Улаангом сум/-234.0 сая төгрөг,
- ✓ Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж, Улаангом сум багц 1-750.0 сая төгрөг,
- ✓ Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тариалан сум, Хархираа баг/ багц1-236.0 сая төгрөг,
- ✓ Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Сумын цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөл /Увс, Тэс сум/ багц 2-180.0 сая төгрөг,
- ✓ Улаангом сумын 8-р цэцэрлэгийн дулааны шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум/-118.6 сая төгрөг
- ✓ Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ Ухаалаг тоолуур нэвтрүүлэх, худалдан авах /Увс, Улаангом сум/- 787.6 сая төгрөг,
- ✓ Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах /Увс, Өлгий сум/ багц 3-146.9 сая төгрөгийн гэрээний дүнгээс 128.5 сая төгрөгийн хөрөнгийг Өлгий сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгасан байна. Үлдэгдэл 18.4 сая төгрөгийн "Увс цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ний өмчлөлд шилжих хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- ✓ Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Увс/-390.1 сая төгрөгийн гэрээний дүнгээс 35.8 сая төгрөг тоног төхөөрөмжийг 6 сумын Эрүүл мэндийн төв болон Дун цагаан өрхийн эрүүл мэндийн төв данс бүртгэлд тус тус бүртгээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон дээрх хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгах аймгийн Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж өгөв.

Харин Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжиж эхэлсэн Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/-5,117.2 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий барилгыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр улсын комисс хүлээн авсан байна. Наранбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 29 дүгээр албан бичгийн дагуу 2023 оны санхүүгийн тайландаа гэрээний нийт өртгөөр нь данс бүртгэлд тусгасан байна. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд уг төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 576.6 сая төгрөгийг тусган баталснаас гүйцэтгэлээр 511.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас дээрх төсөл, арга хэмжээний нийт гүйцэтгэл болох 5,101.6 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгах тухай 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 16 дугаар албан бичгийг хүргүүлсний дагуу аймгийн Засаг даргын тамгын газар бусад хангамжийн бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Иймд давхардуулан бүртгэсэн, данс бүртгэлд тусгах бодит өртөг өөрчлөгдсөн асуудлыг шийдвэрлэж ажиллах зөвлөмжийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт өгөв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Увс аймагт хэрэгжихээр батлагдсан 55 төсөл, арга хэмжээ, Эрчим хүчний сайдын багцаас эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээнээс тайлант онд хэрэгжиж улсын комисс хүлээн авч байнгын ашиглалтад оруулсан 32 төсөл, арга хэмжээ байгаагаас 6 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

## Хүснэгт 29. Зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй төсөл, арга хэмжээ

№	Байгууллагын нэр	Нийт үнэ /сая төгрөг/	Ашиглаж эхлээгүй шалтгаан
1	Эрүүл мэндийн төвийн автомашин /Увс, Улаангом сум, 2, 8 дугаар баг/	160.0	Тухайн автомашиныг Улаангом сумын 2,8 дугаар багийн дарга нар албан ажилдаа ашиглаж байна.
2	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц4 Чацарганы хөргүүртэй зоорины тоног төхөөрөмж, тусгаарлагч материал, сэлбэг хэрэгсэл	100.0	Сендевчин барилгын материал, хөргүүрийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсан. Барилга угсрах ажил зарлагдан, ажлыг хүлээн авснаар ашиглаж эхлэхээр хүлээгдэж байна.
3	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материал	100.0	Өвөлжөө, хаваржааны газарт модон банзан өвсний хашаа, малын хашаа баригдсан. Ашиглаж эхлээгүй байна.
4	Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж	450.0	Хатуу оёдлын буюу гутлын тоног төхөөрөмж 79 ширхэг /нэр төрөл/ өрөөнүүдэд суурилуулж түрээсэлсэн боловч тоног төхөөрөмжүүд цахилгаан холболт хийгдээгүйн улмаас ашиглагдаж эхлээгүй байна.
5	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ Багц 2 Зөөлөн оёдлын тоног төхөөрөмж иж бүрдэл	350.0	Зөөлөн оёдлын зориулалтай 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэгдсэн боловч тоног төхөөрөмжүүд цахилгаан холболт хийгдээгүйн улмаас ашиглагдаж эхлээгүй байна.
6	Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/	2,300.95	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 20/06 дугаар тогтоолоор Бизнес инкубатор төвийн барилга, Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих төвийн үйл ажиллагааг нэгтгэн удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгжийн аймгийн ЗДТГ-ын дэргэд "Бизнесийн хөгжлийг дэмжих төв" нэртэйгээр байгуулсан байна. Бизнес инкубатор төвийн барилгыг 2024 онд ашиглалтад хүлээн авсан бөгөөд одоогоор түрээсийн үйл ажиллагаа зарлагдаагүй, ашиглалтгүй байна.

Эх сурвалж: 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх төсөл, арга хэмжээнээс Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ багц 1 Зүүнговь цөм сүргийн нэгжийн тоног төхөөрөмж, материал гэсэн 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд өвөлжөө, хаваржааны газарт модон банзан өвсний хашаа, малын хашаа баригдсан нь 2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин "Шинэ хөдөө" төслийн хүрээнд хэрэгжсэн 240.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цөм сүргийн үржлийн нэгжид хурган хуц,

шаардлагатай тоног төхөөрөмж, өвс тэжээл /Малчин, Зүүнговь сум/" гэсэн арга хэмжээний хүрээнд бэлтгэгдсэн 600 хурган хуцанд зориулан хийгдсэн ажил байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдаж 2023 онд хэрэгжүүлсэн уг төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотойгоор илэрсэн зөрчилд үндэслэн Бусдад давуу байдал бий болгосон, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах саналыг 2023 оны 04 дүгээр сарын 244 дүгээр бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж байсан.

Түүнчлэн тухайн бэлтгэсэн 600 хурган хуц бүгд үхэж үрэгдсэн байна. Зүүнговь сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 67 тоот хүсэлтийг үндэслэн аймгийн Мал эмнэлгийн газрын хяналтын улсын байцаагч Н.Батбаяр, шимэгч дэх халдваргүй өвчин, эм био бэлдмэл хариуцсан мэргэжилтэн очиж 600 хурган хуцын сэг зэмийг бийрч дугаартай нь тулгаж хянаад 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 08-31-03/386-05 дугаар “Хурган хуцны хорогдлын шалтгаан тогтоох тухай” дүгнэлт гарган булж устган ариутгал халдваргүйжүүлэлт хийжээ.

Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит үр дүн гараагүй байхад төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хөгжүүлэхээр дараагийн ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн нь тухайн хөрөнгө хэрхэн ашиглах нь тодорхойгүй байдалд хүргэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн дээрх 6 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглах асуудлыг шийдвэрлэх зөвлөмж өглөө.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шинээр хэрэгжүүлэхээр салбар яамдад хүргүүлсэн 86 төсөл, арга хэмжээний саналаас 12 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн тухай хуульд тусган баталжээ.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсөвгүй 6, урсгал зардлын тооцоололгүй 2, хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 3, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 3, нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох төсвийн шаардлага хангаагүй 12 төсөл, арга хэмжээг төлөвлөн тусгасан байна.
3. Нээлттэй тендер шалгаруулалтаар 18,934.1 сая төгрөгийн 28, харьцуулалтын аргаар 110.0 сая төгрөгийн 2, нийт 19,044.1 сая төгрөгийн 30 худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцаас эрх шилжиж ирсэн 3,374.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлт баталгаажаагүйгээс худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.
5. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалттай холбоотойгоор Сангийн яаманд 5 гомдол гаргасан байна.
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтыг зөрчин 284.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулсан байна.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 25 төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.
8. Эрх шилжээгүй 25,232.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, эрх шилжсэн 16,473.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгээгүй байна.
9. Улаангом дулааны 2-р станцын зуухны барилгын их засварын ажлыг хүлээн авах комиссын актаар өгсөн үүргийн биелэлт бүрэн хангагдаагүй байна.
10. Хэрэгжиж дууссан 9 төсөл, арга хэмжээний 2,460.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, Наранбулаг сумын 640 суудалтай сургуулийн барилгыг данс бүртгэлд давхардуулан тусгасан байна.
11. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3,460.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

**Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:**

### **Аймгийн ИТХ, Засаг даргад**

1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн хүлээн авсан 6 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглах.

### **Аймгийн Засаг даргад:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.

### **Аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт:**

1. Гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчээр хийлгэж хүлээн авах.
2. Улаангомын дулааны 2-р станцын зуухны барилгын их засварын ажлыг ашиглалтад оруулах комиссын өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангуулах.

### **Аймгийн Орон нутгийн өмчийн газарт**

1. Хэрэгжиж дууссан 9 төсөл, арга хэмжээний 2,460.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Наранбулаг сумын 640 суудалтай сургуулийн барилгыг данс бүртгэлд давхардуулан бүртгэсэн асуудлыг шийдвэрлэх.

**Аудитын дүгнэлтээс дараах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлж байна.**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсөвгүй 6, урсгал зардлын тооцоололгүй 2, хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 3, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 3, нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох төсвийн шаардлага хангаагүй 12 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Цаашид хууль тогтоомжид нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж байх талаарх зөвлөмжийг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой 5 гомдол гаргасныг Сангийн яам хянан үзэж захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж, тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг зөвлөмж болгосон байна. Зөвлөмжийн дагуу 4 тендерт үнэлгээний хороо дахин хуралдсан ч сонгон шалгаруулалтыг өмнөх байдлаар нь баталгаажуулсан байна. Нэг

тендерт үнэлгээний хороо дахин хуралдаагүй, хянан үнэлээгүй байна. Сангийн яамны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, үнэлгээний хороо дахин хуралдсан ч шийдвэртээ өөрчлөлт оруулаагүй тохиолдлыг шийдвэрлэх хууль, эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүйгээс маргаан үүсч шүүхийн байгууллагад шилжих, төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэж байна. Иймд дээрх 5 худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж чиглэл өгч ажиллах талаар ҮАГ-ын нэгтгэл тайланд тусгаж холбогдох яам, агентлагт уламжлуулах саналыг хүргүүлж байна.

3. Төрийн үйлчилгээний анхан шатны нэгжийн тоног төхөөрөмж /Увс/ гэсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 597.9 сая төгрөгийн 22 автомашиныг, Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл Багц 3, Сумын багийн эмч нарт автомашин, тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 279.7 сая төгрөгийн 14 автомашиныг тус тус бэлтгэн нийлүүлсэн байна. Уг автомашинууд дээр шинэ хөдөө “УВС” гэсэн бичигтэй ирсний “УВС” гэсэн нь U.vs >Увс аймаг, B.business > Бизнес, C.luster > Кластер гэсэн утгатай хувийн аж ахуйн нэгжийн гаргасан брэндийн нэрийн товчлол байна. Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн тоног төхөөрөмж дээр сурталчилгааны чанартай нэршил байршуулахгүй байх зөвлөмжийг ҮАГ-ын нэгтгэл тайланд тусгуулах санал хүргүүлж байна.